



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/401

Булган сум

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд
хяналт тавих ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.2.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17 дугаар зүйлийн 1.5, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 5633:2023 стандартыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг байгуулсугай.

2.Хяналт тавих ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж, эргэн танилцуулж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 09-ны/ний өдрийн
А/401 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хяналт тавих
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Гишүүд:
- Х.Чинзориг (Онцгой байдлын газрын Гал түймрийн
аюулгүй байдлыг хангах улсын байцаагч, Хошууч)
 - Б.Лхаеийлам (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
газрын Хүүхдийн эрхийн Улсын байцаагч)
 - Д.Төрбат (Цагдаагийн газрын Замын цагдаагийн
хэлтсийн ахлах зохицуулагч, Хошууч)
 - М.Мөнхгэрэл (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний
стандарт, чанарын хяналтын Улсын ахлах байцаагч)
 - Г.Байгалмаа (Эрүүл мэндийн газрын Ахмад тастан,
тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл хариуцсан
мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/401 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

ЗОРИЛГО:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Хүүхдийн зуслангуудыг бүртгэлжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, MNS 5633:2023 стандартын хэрэгжилтийг хангах, хүүхдийн эрсдэж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Булган аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлдэг Хүүхдийн зуслан, Гэр бүл-хүүхдийн зуслан, Гадаад хэлний зуслан, Спортын зуны зуслан, Скаутын зуслан, Хөдөлмөр зуслан.

ХУГАЦАА:

2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд

ХИЙГДЭХ АЖИЛ:

- Зуслангийн барилга байгууламжийн ерөнхий шаардлага, галын аюулгүй байдалд дүгнэлт хийх.
- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог хангасан, хүүхдэд ээлтэй хөгжлийн орчин бүрдүүлсэн эсэх хяналт тавих.
- Эрүүл хоол хүнс, хоолны газрын үндсэн шаардлагад хяналт хийх.
- Зуслангийн захиргаа батлагдсан маршрутын дагуу хүүхэд тээвэрлэх
- Хүүхдийн зусланд ажиллах хүний нөөцөд тавих ерөнхий шаардлага хангах эсэхэд хяналт хийх.